



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 8/78

Улаанбаатар хот

**Соёлын төв өргөөний барилгын
бүртгэлийн үнийг нэмэгдүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/296 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн Соёлын төв өргөөний барилгад хийгдсэн дээврийн их засварын гүйцэтгэлийн дүн 988,989,500.0 /есөн зуун наян найман сая есөн зуун наян есөн мянга таван зуун/ төгрөгөөр барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэн бүртгэх, 28,459,156.0 /хорин найман сая дөрвөн зуун тавин есөн мянга нэг зуун тавин зургаан/ төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг холбогдох дансандаа тус тус бүртгэн авахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.


2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, Санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2020 оны 03 дугаар сарын 16 -ны өдрийн
 А/78 дугаар тушаалын хавсралт



Бүртгэх эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар

/төгрөгөөр/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал		Бүртгэх үнэ		Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
					Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Нийслэлийн Соёлын төв өргөөний дээврийн засвар	Дээврийн засвар /PVC мембран дээвэр-13367м2, шифрэн дээвэр-2150м2, пирамид целлодон дээвэр-12ш/	Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Сүхбаатарын талбайн зүүн талд	2019	м2	16207	61,022.37	988,989,500	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт /НЗД-ын 2019 оны А/296 дугаар захирамж/
		2019		ш	120	237,159.63	28,459,156		
		Нийт бүртгэх хөрөнгийн дүн						1,017,448,656	